



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас 70-59-24-39 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.08.17 № 08/53

САЙХАНОВОО  
СҮМҮН ЗАСАГ ДАРГА  
Б.ТҮВШИНБААТАР ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын үр дүнд нийцлийн аудит хийх явцад 75,900,000.00 /Далан таван сая есөн зуун мянган/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр баригдсан 40,000,000.00 төгрөгийн өртөгтэй “Найз баг”, “Мааньт баг”-ийн төвийн барилгуудад хувийн хэрэг нээж хөтлөөгүй.

Энэ нь Барилын тухай хуулийн 33.1.18. -д /Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмыг батлах;/, 46.1.2. /энэ хуулийн 33.1.18-д засан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх;/, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалаар батлагдсан барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмын 1.3-д /Барилга байгууламжийн хувийн хэрэг нь тухайн барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд хийгдсэн өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэл, их засварын ажил, үзлэг шалгалт, гарсан эвдрэл, гэмтэл, согогын талаарх мэдээлэл, уг барилга байгууламжийн үндсэн үзүүлэлтийг агуулсан баримт бичиг байна./ гэж заасны;

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 12,000,000.00 төгрөгийн өртөгтэй “Сумын төвийн худгуудын засварын”-ын ажлыг бүртгээгүй, санхүүгийн тайландаа тусгаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, 14.4.2.-т /бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагас/; Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Орон нутгийн хуулийн этгээдийн олж авсан эд хөрөнгийг бүртгэх”-журмын 3 дугаар зүйлийн 3.2-т /Улсын хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тооног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан Улсын комисс /Ажлын хэсэг/-ын акт, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн зохих баримт материалыг үндэслэн тухайн төсөл хэрэгжсэн байгууллага нь тайлан балансдаа шууд бүртгэн авна/ заасныг;

3. Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны санхүүгийн тайлангаар 23,900,000.00 төгрөгийн авлагыг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнэ шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах,

1001000712

удирдах;/ 20.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад материалыг шаардан гаргуулах,/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.4-д /Байгууллага иргэдтэй үссэн материалылаг дүнтэй буюу насхилт өндөртэй авлагага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй/, 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр баригдсан “Найз баг”, “Мааньт баг”-ийн төвийн барилгуудад хувийн хэрэг нээж хөтлөх, Барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 71 дүгээр тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллах.
2. 2017 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланд “Сумын төвийн худгуудын засварын”-ын ажлыг бүртгэж, санхүүгийн тайланд тусгах,
3. Харилцагч байгууллагатай өглөг, авлагын тооцоог нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, барагдуулах ажлыг зохион байгуулах.

Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 04 дүгээр сарын 25-ны дотор аймгийн Аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Сайхан-овоо сумын Засаг дарга /Б.Түвшинбаатар/, Засаг даргын орлогч /Т.Гэрэл/, нягтлан бодогч /З.Цэдэнрулам/ нарт хариуцуулав.

#### АЛБАН ШААРДЛАГЫГ

<b>ӨГСӨН:</b> АХЛАХ ШИНЖЭЭЧ  Д. ИХБАЯР	<b>ЗӨВШӨӨРСӨН:</b> ЗАСАГ ДАРГА  Б. ТҮВШИНБААТАР
	
ЗКА0006 №033475	ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  З. ЦЭДЭНРУЛАМ
	Т.ГЭРЭЛ
	НЯГТЛАН БОДОГЧ  Т. ГЭРЭЛ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.